



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 21 өдөр

Дугаар A/480

Эрдэнэт

Шагнах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын журам"-ын 3.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өндөр нутаг дэвсгэрт 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдөр орсон хүчтэй мөндөр, аадар борооны улмаас үүссэн үерийн усанд урссан иргэдийн амь насыг аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Баян-Өндөр сумын Шанд багийн иргэн Эрдэнийн Цагаанхүү, Эрдэнэ багийн иргэн Жамбалдоржийн Баатар, 17 дугаар сургуулийн жижүүр Дэмчигийн Амарсайхан, Даваат багийн иргэн Шагдарын Гомбо, Яргуйт багийн иргэн Соёлмаагийн Отгон-Эрдэнэ нарыг Орхон аймгийн "Хүндэт тэмдэг", мөнгөн шагналаар шагнаж урамшуулсугай.

2.Шагналд зарцуулагдах 500000 /Таван зуун мянган/ төгрөгийг орон нутгийн бусад зардлын шагнал урамшууллын сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ